



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 5/51

Бодь

Б.Болортуяаг Соёлын төвийн даргаар  
түр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дүгээр зүйлийн 47.1, Соёлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан тухай Авлигатай тэмцэх газрын 2022 оны 05/5680 дугаар тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Соёлын төвийн даргаар Батбаатарын Болортуяаг 2022 оны 05 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн түр томилон ажилуулсугай.


2.Б.Болортуяагийн үндсэн цалинг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын дагуу ТҮСҮ-5 дэх шатлал 895,945 (Найман зуун ерэн тав есөн зуун дөчин таван мянган) төгрөгөөр тогтоосугай.

3.Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтад орон нутагт ажилласны нэмэгдэл 15 хувиар нэмэгдлийг бодож олгосугай.

4.Б.Болортуяагийн цалин, нэмэгдлийг тогтоосон хувь хэмжээгээр 2022 оны 05 дугаар сарын 09-ны өдрөөс эхлэн бодож олгохыг Нягтлан бодогч (Ш.Оюунцэцэг)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА



Р.БАТЖАРГАЛ

642201093